



**ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДРЫН ЭМИЙН ХАНГАЛТЫГ САЙЖРУУЛАХ
ДЭЛХИЙН ПЛАТФОРМЫН ХҮРЭЭНД ЭХЭМҮТ-Д НИЙЛҮҮЛЭГДЭХ
ЭМИЙГ ХҮЛЭЭН АВАХТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хэрэгжүүлэх байгууллага: Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Хамтран ажиллах байгууллага: Эрүүл мэндийн яам

Техникийн ба Санхүүгийн дэмжлэг: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Хугацаа: 2025 оны 05 дугаар сараас 11 дугаар сар

**УЛААНБААТАР ХОТ
2025 ОН**

ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДРЫН ЭМИЙН ХАНГАЛТЫГ САЙЖРУУЛАХ ДЭЛХИЙН ПЛАТФОРМЫН ХҮРЭЭНД ЭХЭМҮТ-Д НИЙЛҮҮЛЭГДЭХ ЭМИЙГ ХҮЛЭЭН АВАХТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ДЭМБ-аас 2018 онд “Хүүхдийн хорт хавдрын эсрэг ГЛОБАЛ санаачилга”-ыг эхлүүлэн 2030 он гэхэд хавдартай хүүхдийн амьдрах чадварыг 60 ба түүнээс дээш хувьд хүргэж нэмэгдүүлэх, дараагийн 10 жилд эмчилгээний чанар, хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлэх зорилго дэвшүүлсэн. Монгол Улс энэхүү санаачилгад 2021 оноос нэгдэн 3 дахь жилдээ ажиллаж байна. Улс орнуудын эрүүл мэндийн тогтолцоо, хүүхдийн хорт хавдар тэргүүлэх чиглэл нь мөн эсэх зэргээс шалтгаалан дэлхийн улс орнуудын дунд илт тэгш бус байдал байсаар байна. Монгол Улсад 100-120 хүүхэд хорт хавдраар оношлогдож, эмчилгээнд хамрагдсан 3 хүүхэд тутмын нэг нь эмийн гаж нөлөө болон бусад шалтгааны улмаас бүрэн гүйцэт эмчилгээ хийлгэж чадахгүй байна. Хүүхдийн хорт хавдрын тусламж үйлчилгээний ялгаатай байдлыг бууруулах хүрээнд ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, АНУ-ын Хүүхдийн хорт хавдрын судалгааны “Сэйнт Жүүд” (St Jude) эмнэлэг хамтран “Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ” төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд ДЭМБ-ын бүс тус бүрээс 1, нийт 6 орныг сонгосон бөгөөд Номхон далайн баруун бүсээс Монгол Улс сонгогдон үйл ажиллагааг эхлүүлсэн.

Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформд нэгдсэн улс орнуудад хийгдсэн үнэлгээний тайланд эмийг хүлээн авахтай холбоотой зайлшгүй хэрэгжүүлэхээр тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нэмэлт санхүүгийн дэмжлэг үзүүлэх болсон. ЭХЭМҮТ нь “Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ”-ын хэрэгжих гол байгууллагын хувьд зайлшгүй шаардлагатай сургалтууд буюу эмийн тооцооллын болон платформын хяналт үнэлгээний сургалтууд мөн эрүүл мэндийн ажилтнуудад зориулсан хавдрын эмтэй аюулгүй харьцах тасралтгүй сургалтын дараах үйл ажиллагааг ЭМЯ, ЭЭХХЗГ, ЭҮА, СХЗГ, Сэйнт Жүүд хүүхдийн хавдрын судалгааны төвтэй хамтран энэхүү санхүүжилтийн дэмжлэгээр хэрэгжүүллээ.

1. Инженер, техникч нарт зориулсан тоног төхөөрөмжийн хүйтэн хэлхээний техник ашиглалтын сургалт

2. Шинэ эмч мэнэлгийн мэргэжилтэнд зориулан төслөөр нийлүүлэгдэж буй эмүүдийн түгээлт, эмийг зөв зохистой хүлээж авах, хадгалах, түгээх, хэрэглэхтэй холбоотой стандарт арга зүйн сургалт
3. Глобал платформын дата бүртгэл, хяналт үнэлгээ, тайлагнахтай холбоотой сургалт
4. Хүүхдийн хорт хавдрын эмийн тооцоолол гаргах чиглэлээр хүний нөөцийг чадавхжуулах сургалт

НЭГ. ХҮҮХДИЙН ХОРТ ХАВДАРЫН ЭМИЙГ ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЕИЙН ТЕХНИКИЙН ГОРИМЫГ ХАНГАХ, ХҮЙТЭН ГИНЖИН ХЭЛХЭЭНИЙ УДИРДЛАГЫН СУРГАЛТ

2018 онд Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, St.Jude Хүүхдийн Судалгааны Эмнэлэг (АНУ), Олон улсын хорт хавдрын судалгааны агентлаг (IARC) болон дэлхийн бусад түншүүдийн дэмжлэгтэйгээр Хүүхдийн хорт хавдрын эсрэг дэлхийн санаачилгыг эхлүүлсэн. Энэхүү санаачилга нь 2030 он гэхэд дэлхийн хэмжээнд хүүхдийн хорт хавдраар өвчилсөн хүүхдүүдийн 60-с доошгүй хувийг эсэн мэнд амьдруулах зорилготой.

Монгол Улсад сүүлийн 5 жилийн статистик үзүүлэлтээр 0-19 насны хүүхдүүдийн дунд жилд дунджаар 100 гаруй шинэ хорт хавдрын тохиолдол бүртгэгдэж байна. Тус хүүхдийн хорт хавдрын тохиолдлыг бууруулах ажлын хүрээнд хавдрын эмийн хадгалалт, тээвэрлэлт, хяналт шалгалтыг техникийн горимын дагуу хийх шаардлага тулгарч байна.

Тус шаардлагын дагуу төсөл хэрэгжүүлэгч байгууллаг, хамтран ажилладаг эмнэлгийн тасаг нэгжүүдийг хамруулсан “Хүүхдийн хорт хавдрын эмийг хадгалах, тээвэрлэх үеийн техникийн горимыг хангах, хүйтэн гинжин хэлхээний удирдлага буюу тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга, засварын сургалт”-ыг 2025 оны 10 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тухайн сургалтад Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, сувилагч, эмнэлзүйн эмзүйч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техник нар буюу нийт 30 мэргэжилтэн хамрагдсан.

Сургалтын илтгэгч багш нар болон сургалтын агуулгыг дурьдвал:

1. Эм, Эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын мэргэжилтэн Ц.Уянга - Хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулга хийх арга аргачлал, эрх зүйн журам, дүрмүүд
2. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эм зүйн албаны Эмнэлзүйн эм зүйч М.Тэмүүлэн - Хүүхдийн хорт хавдрын хадгалалтад тавигдах шаардлага
3. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, Техникийн ухааны магистр Н.Наранбаатар - Хүүхдийн хавдрын эм хадгалах хөргөгч буюу хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн шалгалт, тохируулга хийх


Сургалтаар онолын болон дадлагын дараах мэдлэгийг олж авсан:

1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт баталгаажилт, шалгалт тохируулга болон эрх зүйн орчин
2. Өвчтөний хяналтын мониторийн симулятор ашиглан өөрсдийн биеээр шалгалт тохируулга хийх
3. Хүүхдийн хорт хавдрын эмийн хадгалалтад тавигдах шаардлага
4. Мөсөн ханатай хөргөгч болон энгийн хөргөгчний ялгаа болон адил талууд
5. Эвдрэлтэй хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн эвдрэлийг илрүүлэх, оношлох
6. Хүйтэн хэлхээнд ашиглагдаж байгаа хөргөгч, хөлдөөгчний хэрэглээ, түүний төрөл, загвар
7. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа
8. Даралтад савны аюулгүй ажиллагаа

Сургалтын бэлтгэл ажлын хүрээнд:

1. Сургалтын удирдамж боловсруулан батлуулсан.
2. Захиргааны барилгын 4 давхарт байрлах “ЧИНГИС ХААН” хурлын танхимийн бэлтгэл байдлыг хангасан.
3. Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварын хэсгийг сургалтын дадлага ажлын орчин болгож бэлдсэн.
4. Засвар хийх шаардлагатай Цусны эмгэг хавдар судлалын тасагт ашиглаж буй хөргөгч болон Нярайн судлалын тасагт ашиглаж буй бакцин хадгалах зориулалттай хөргөгчийг дадлага хийх байранд зөөвөрлөн байрлуулсан.

5. Сургалтад оролцогчдод сургалтын материал болон зарлан мэдээлэх мэдээллийн хуудас бэлдэж 4 газар байрлуулсан.



Зураг 1. Сургалтын материал болон зарлан мэдээлэх мэдээллийн хуудас



Зураг 2. Сургалтын бүртгэл хийж буй нь



Зураг 3. Эм, Эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газрын мэргэжилтэн Ц.Уянга лекцээ орж буй нь




Зураг 4. Суралцагч нар хоёр групп болон өвчтөний хяналтын мониторийн шалгалт тохируулга хийж буй нь



Зураг 5. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эм зүйн албаны Эмнэлзүйн эм зүйч М.Тэмүүлэн лекцээ орж буй нь



Зураг 6. ЗӨСҮТ-ийн эмнэл зүйч, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер нар
Эм зүйн албатай болон хүүхдийн хорт хавдарын эмийн удирдамж заавартай
танилцаж буй нь



Зураг 7. Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эмнэлгийн тоног
төхөөрөмжийн инженер, Техникийн ухааны магистр Н.Наранбаатар лекцээ орж
буй нь






Зураг 8. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникч нар хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн гагнуур хийж буй нь



Зураг 9. Бакцин хадгалах хөргөгчний бүтэцтэй танилцаж, задалж үзэж буй нь



Зураг 10. Цусны эмгэг хавдар судлалын тасгийн хөргөгчинд ферон шахаж,
засварлаж буй нь



Зураг 11. Цайны завсарлага

Сургалтын үр дүн

Энэхүү сургалтаар хүүхдийн хорт хавдарын эмийн хангалтад нөлөөлөх хэмжих хэрэгсэл, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжинд засвар үйлчилгээ хэрхэн хийх, аюулгүй ажиллагаа хангах онолын болон дадлага ажлын мэдлэг мэдээлэлтэй болсон.

Мөн эмч, сувилагч нар эмнэлгийн тоног төхөөрөмж, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийлгэх, баталгаатай техник төхөөрөмжийн хангалт хийх нв хэр үр дүнтэйг ойлгож авсан.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер техникч нар нь хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх, хийн гагнуурын хийх анхан шатны мэдлэгтэй болсон нь үр дүнтэй сургалт болсоныг харуулж байна.

ХОЁР. ХИМИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА СЭДЭВТ СУРГАЛТ

“Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ” төслийг 2023-2027 оны хооронд хэрэгжүүлэхээр эхлүүлсэн. Уг төслийг хэрэгжүүлснээр ДЭМБ-ын урьдчилсан баталгаажуулалтад хамрагдсан болон эмийн хатуу зохицуулалттай улс оронд үйлдвэрлэгдсэн чанарын баталгаатай эмийг хүүхдийн хорт хавдрын эмчилгээнд хэрэглэснээр эмчилгээний чанар, хүртээмж, үр дүн нэмэгдэж хорт хавдартай хүүхдүүдийн амьдрах чадвар нэмэгдэх боломжтой юм. Энэхүү төслийн хүрээнд ДЭМБ-аас 22 нэр төрлийн химийн эм, тариа нийлүүлэгдэн ирж байгаа.

Эс хордуулах эмийг хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, найруулан бэлтгэх, эмчлүүлэгчид хэрэглэх, хог хаягдлыг устгахдаа баримтлах үйл ажиллагааны зааврыг мөрдүүлэн ажиллах зорилгоор эс хордуулах эмүүдтэй харьцдаг мэргэжлийн багт химийн эмчилгээний үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгөх зайлшгүй шаардлагатай. Эс хордуулах эмүүдтэй харьцдаг мэргэжлийн багт эм зүйч, эм найруулагч, сувилагч, эмч болон хог хаягдалтай харьцдаг ажилчид багтана. Иймд эс хордуулах химийн эм тариаг найруулан бэлтгэхбараа материал хүлээн авах, хүүхдийн хортхавдрынэмийнхадгалалт, түгээлт, хорт хавдрын эмийн заавар болон эс хордуулах эмийг найруулах үйл ажиллагааны үед өртөх эрсдлийг бууруулах, эмийн аюулгүй байдлыг хангах зорилгоор бэлтгэлээ.

Зорилго

Хүүхдийн хорт хавдрын эмийн хадгалалт, түгээлт, хорт хавдрын эмийн хэрэглээ, гаж нөлөөг бүртгэхтэй холбоотой стандарт ажиллагааны зааврын талаар тасралтгүй сургалтыг зохион байгуулах.

Энэхүү зорилго зорилтын хүрээнд ЭХЭМҮТ нь ДЭМБ-ын санхүүжилттэй “Хүүхдийн хорт хавдрын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ” төслийн хүрээнд эс хордуулах эмтэй ажилладаг мэргэжлийн багийн аюулгүй ажиллагааны мэдлэг, чадварыг сайжруулах зорилгоор сургалтыг зохион байгуулав. Сургалт нь

1. Эс хордуулах эмийн ангилал, үйлчлэл, хор аюулын үнэлгээ
2. Эмийн хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн стандарт
3. Химийн эмчилгээний үеийн хамгаалах хувцас, хэрэгслийн зөв хэрэглээ

4. Эмийн найруулга, бэлтгэл, хяналтын орчны шаардлага
5. Эмийн хэрэглээний үеийн эрсдэл ба урьдчилан сэргийлэх арга хэмжээ
6. Хог хаягдлын ангилал, цуглуулалт, хадгалалт, устгал
7. Ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдал, осол гэмтлийн үед авах арга хэмжээ
8. Гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл дамжуулалт гэсэн агуулгын хүрээнд ЭХЭМҮТ-ийн Эм зүйн тасаг, Цусны эмгэг хавдар судлалын тасгийн эмч, ажилчид мөн эс хордуулах эм ашигладаг Бөөр дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг болон Зүрх судас холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эмч, эм зүйч, сувилагч болон эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан онолын мэдээлэл, дадлага гэсэн хоёр үе шаттай явагдсан.

Онолын сургалт 2025 оны 10 сарын 30-нд лекц, хэлэлцүүлгийн хэлбэрээр; дадлага сургалтыг БНСУ-д явагдсан ажлын байрны сургатад хамрагдсаны дараа зохион байгуулахаар төлөвлөсөн.



Сургалтаар хорт хавдрын эмийн хадгалалт, бэлтгэл, хэрэглээ, гаж нөлөөний бүртгэлийн стандарт ажиллагааны зааврыг танилцуулах, ажилтнуудын аюулгүй ажиллагааны мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилгоор эс хордуулах эмийг зөв найруулан бэлтгэх чадвар, хамгаалах хувцас, хэрэгслийг зөв өмсөх, тайлах чадвар, эмийн хаягдлыг зөв ангилж устгах чадвар, осол, асгаралт, алдагдал үүссэн үед хариу арга хэмжээ авах чадвар, гаж нөлөө, сөрөг үйлдлийг бүртгэж мэдээлэх чадваруудыг эзэмшсэн ач холбогдолтой сургалт болсон.



БНСУ-д ЭХЭМҮТ-ийн гемато-онколог 2 эмч, 2 сувилагч, 4 эм зүйч багаар ДЭМБ-ын хамтын ажиллагааны төв болох Хавдрын Үндэсний төвд 2025 оны 11 сарын 3-аас 11 сарын 14 хооронд ажлын байрны дадлага сургалтад хамрагдсан туршлага солилцон, өөрсдийн ажлын байран дээр ирэн сурсан мэдсэн туршлагаа хамт олондоо ажлын байрны дадлага сургалт явуулсан нь үр өгөөжтэй сургалт боллоо.

2025 оны 11 сарын 3-нд Хавдрын үндэсний төвтэй танилцсан, уг төв нь 2000 онд байгуулагдсан. Тус төв нь судалгаа шинжилгээ, өвчтөний тусламж үйлчилгээ, боловсрол, сургалт, хорт хавдрын эсрэг үндэсний хөтөлбөрүүдийг дэмжих замаар хорт хавдрын өвчлөл, нас баралтыг бууруулах замаар үндэсний эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сайжруулахыг эрмэлздэг. Хүүхдийн цус хавдрын тасаг нь хэвтэн эмчлүүлэх 20 ортой, эмнэлэгт суурилсан сургуультай, 3 хүүхдийн цус, хавдрын эмч ажилладаг.



Өдөр бүр 9:00 цагаас хэвтэн эмчлүүлэгчдийг тойрон үзэх, амбулаторийн эмчийн үзлэгт хамтран оролцсон.



2025 оны 11 сарын 4-нд Хавдрын үндэсний төвийн Хүүхдийн цус хавдрын эмч Park Hee Jin профессор “БНСУ-ын хүүхэд, залуучууддын дундах өвчлөл, хорт хавдрын амьдрах чадамж” сэдвээр илтгэл танилцуулав.

2025 оны 11 сарын 6-нд Солонгос улсын хүүхдийн нийгэмлэгийн конференцэд оролцсон.



11 сарын 7-нд Солонгос улсын цусны өвчний нийгэмлэгийн конференцэд оролцсон.



11 сарын 8-нд Солонгос улсын хавдрын нийгэмлэгийн конференцэд тус тус оролцон шинэ мэдээлэл сонсох боломж олдсон.



11 сарын 10-нд Хавдрын Үндэсний Төвийн захирал хүлээн авч уулзан, цаашид хамтын ажиллагаа, сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэн ажиллах санал солилцсон.



11 сарын 11-нд Хүүхдийн хавдрын эмчилгээний явцад хийгдэх тархи нугасны шинжилгээ авах, нугасаар хими эмчилгээг рентген хяналтын дор хийгдэх ажилбартай танилцлаа.



11 сарын 13-нд Хүүхдийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээтэй танилцав.



11 сарын 14-нд Чөмөг шилжүүлэн суулгах тасгийн үйл ажиллагаатай танилцав.





Дээрхи сургалтын хугацаанд хэвтэн эмчлүүлж байгаа болон өдрийн эмчилгээ, амбулаторын эмчилгээнд буй Цочмог лимфобластны лейкоз, Цочмог миелобластны лейкоз, Цочмог промиелоцитын лейкоз, Остеосаркома, Юинга саркома, Тархины хавдрууд, Аденокарцинома, Гемофили А, удамшлын Сфероцит зэрэг эмгэгүүдтэй өвчтөнүүдийг хамтран үзэж, оношилгоо, шинжилгээтэй танилцан, протокол эмчилгээ, хими, бай эмчилгээний хүндрэл зэргийг асууж лавлан, санал солилцов.



Эх орондоо эргэн ирсний дараа дадлага сургалтыг 2025 оны 11 сарын 25-ны өдөр найруулга бэлтгэл, хамгаалах хувцас өмсөлт, асгаралт, ослын үед авах арга хэмжээний чиглэлээр гадаад сургалтыг агуулгаар баяжуулсан онол, дадлага хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. Сургалтад Эм зүйн тасаг, Цусны эмгэг хавдар судлалын тасгийн эмч, ажилчид мөн эс хордуулах эм ашигладаг Бөөр дотоод шүүрлийн эмгэг судлалын тасаг болон Зүрх судас холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эмч, эм зүйч, сувилагч болон эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон.








ГУРАВ. DHIS ЦАХИМ СИСТЕМД ЭМИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ТАЙЛАН ӨГӨГДӨЛ ОРУУЛАХ СУРГАЛТЫН ТАЙЛАН


Хүүхдийн хорт хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах дэлхийн платформ (Глобал платформ) нь хүүхдийн хорт хавдрын зайлшгүй шаардлагатай эмчилгээний хүртээмжийг сайжруулах зорилготой.

Хорт хавдрын эмийг хүлээн авч буй тухайн байгууллагад зориулсан эмийн хэрэглээний өгөгдөл оруулах заавар тэдгээрийн үзүүлэлтүүдтэй холбоотой өгөгдлийг хэрхэн зөв оруулах, удирдах талаар тодорхой зааварчилгаа бүхий сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд зохион байгуулсан бөгөөд тус сургалтад ЭХЭМҮТ-ийн Цусны эмгэг хавдар судлалын тасгийн 4 их эмч, Эм зүйн албаны 9 эм зүйч, 2 эм найруулагч, Нэгдсэн лабораторын тасгийн 1

их эмч, Эрдэм шинжилгээний салбарын 2 их эмч, Статистик мэдээллийн албаны 2 статистикийн эмч, ДЭМБ-ын Хүүхдийн хорт хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах платформын зөвлөх, ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй байдал тандалт судалгааны хэлтэсийн 6 мэргэжилтэн, ЗӨСҮТ-ийн агуулахын 3 эм зүйч, нийт 30 хүнийг хамруулсан.



Глобал платформын үр ашгийг үнэлэх, мэдээллийн санг үүсгэх, эмийн хэрэглээний тайлан мэдээллийг улирал бүр илгээх нь чухал юм. Энэхүү сургалтаар мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс DHIS цахим системд мэдээлэл оруулах зааварчилгааг алхам алхмаар эмнэлгийн эмч, эм зүйч, сувилагч нарт зориулан DHIS цахим системд өгөгдөл оруулах 50 хуудас бүхий гарын авлагыг монгол хэл рүү орчуулан бэлтгэсэн.




Эрүүл мэндийн байгууллагын тайлангийн дата багц

Эрүүл мэндийн байгууллагын тайлангийн өгөгдлийн багц нь нийлүүлэгдэж буй эмүүдийн тоо хэмжээ, эх сурвалж, болзошгүй гаж нөлөөний талаарх үндсэн хувьсагчдыг цуглуулдаг мэдээллийн багц юм.

Тайлангийн хугацаа нь тайлангийн үргэлжлэх хугацаанаас хамаарч өөрчлөгдөнө. Тайлангийн эхний жилд тухайн байгууллага эрүүл мэндийн байгууллагын тайлангийн мэдээллийн багцыг улирал бүр тайлагнаж байх ёстой. Хоёр дахь жилээс эхлэн тус байгууллага зургаан сар тутамд ижил мэдээллийг тайлагнах боломжтой болно. Системийн администраторууд үе үе солих ажлыг зохион байгуулна. Энэхүү баримт бичигт жишээг ихэвчлэн улирлын тайланд үндэслэсэн боловч системийн ашиглалтын гол алхмууд нь тайлант үеэс үл хамааран ижил байдаг.

Өгөгдөл оруулах программыг нээснээр хэрэглэгч өөрийн байгууллагын нэгжийн цэсэнд байгаа тайлагнаж буй улс болон оруулах улирлын дагуу тайлагнах хугацааг сонгох ёстой.



Хэрэглэгч эхлээд тайлагнагчийн нэр, холбоо барих хаягийг оруулах ёстой.

Name of person reporting:

Jane Doe

Email Address of Person Reporting:

Jane.doe@organization.com

Систем нь зөвхөн хүчинтэй хаягийг хүлээн авдаг гэдгийг анхаарах нь чухал бөгөөд ингэснээр бүтэцлэгдсэн имэйл хаяг дутмаг (жишээ нь: @ тэмдэг дутуу байх) өгөгдөл оруулахад алдаа заана.

Email Address of Person Reporting:

Jane.doe@organization.com

Энэхүү сургалтын хүрээнд:

1. DHIS Цахим систем хэрхэн бүртгэл үүсгэн нэвтрэх тухай
2. Байгууллагын тайлан илгээх арга
3. Эрүүл мэндийн байгууллагын тайлангийн дата багц хэрхэн үүсгэх
4. Эмийн гаж нөлөөг тус платформд хэрхэн бүртгэн баталгаажуулах
 - Эмийн гэнэтийн болон шинэ гаж нөлөөг бүртгэн мэдээллэх
5. Эрүүл мэндийн байгууллагын эмийн хэрэглээний тайлангийн өгөгдөл оруулах
6. Эрүүл мэндийн байгууллагын нөөц дууссан талаар тайлан мэдээлэл оруулах
7. Улс орны тайлангийн өгөгдөл оруулан баталгаажуулах арга
 - Улс орны хэрэглээний тайлан илгээх арга
 - Улс орны нөөц дуусах тайлан илгээх аргыг алхам алхамаар зааварчилан танилцуулсан.

ДӨРӨВ. ХҮҮХДИЙН ХАВДРЫН ЭМИЙН УРЬДЧИЛСАН ТООЦООЛОЛ ХИЙХ СУРГАЛТ

Хүүхдийн хорт хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах дэлхийн платформ (Глобал платформ) нь хүүхдийн хорт хавдрын зайлшгүй шаардлагатай эмчилгээний хүртээмжийг сайжруулах зорилготой.

Хорт хавдрын эмийг хүлээн авч буй тухайн байгууллагад зориулсан эмийн хэрэглээний урьдчилсан тооцоолол хийх талаар тодорхой зааварчилгаа бүхий сургалтыг Глобал платформ төслийн эмийн мэргэжилтэн Анжали Шривастава хүүхдийн хорт хавдрын өнөөгийн нөхцөл байдал, эмийн урьдчилсан тооцоолол хийх ач холбогдол, Мола алессо Chemoglobe системийг хэрхэн ашиглах талаар сургалт мэдээллийг 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, мэргэжилтнүүдтэй цахимаар холбогдон аман синхрон орчуулгатайгаар зохион байгуулсан. Тус сургалтад ЭХЭМҮТ-ийн Эм зүйн албаны 5 эм зүйч, 1 эм найруулагч, Цусны эмгэг хавдар судлалын тасгийн 4 их эмч, 2 сувилагч, ДЭМБ-ын Хүүхдийн хорт хавдрын эмийн хүртээмжийг сайжруулах платформын зөвлөх мэргэжилтэн, ЭЭХХЗГ-ын Эмийн аюулгүй байдал тандалт судалгааны хэлтэсийн 2 мэргэжилтэн нийт 15 хүн хамрагдсан.



Глобал платформын хүрээнд нийлүүлэгдэж буй эмийн хэрэглээг урьдчилан тооцоолох нь тухайн жилийн эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх болон хүүхдийн хорт хадврын эмийн тасалдал үүсэхээс сэргийлэх зэрэг чухал ач холбогдолтой юм. Энэхүү сургалтаар Хүүхдийн хорт хадврын эмийн урьдчилсан тооцооллыг хийх тухай гарын авлагыг монгол хэл рүү орчуулан бэлтгэсэн.

ЭХ ХҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ ДЭЛХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА	ГАРЧИГ
ХОРТ ХАВДАРТАЙ ХҮҮХДИЙН ЭМИЙН ХЭРЭГЦЭЭГ УРЬДЧИЛАН ТААМАГЛАХ АРГУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ХЭВЛЭЛИЙН ТОЙМ	ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ 3
	ТОВЧ УТГА 4
	УДИРТГАЛ 6
	ХЭВЛЭЛИЙН ТОЙМ БЭЛТГЭСЭН АРГА, АРГАЧЛАЛ 9
	ХЭВЛЭЛИЙН ТОЙМЫН ҮР ДҮН 10
	1. Эмийн хэрэгцээг урьдчилан таамаглах статистикийн загваруудыг харьцуулсан үр дүн 10
	1.1.2. Нэг хөдөлгөөнт дунджийн арга 16
	1.2.2. Жинлэсэн хөдөлгөөнт дунджийн арга 18
	1.2.3. Нэг экспоненциал жигдрүүлэлтийн арга 21
	1.2.4. Хоёр экспоненциал жигдрүүлэлтийн арга 23
	1.2.5. Гурван экспоненциал жигдрүүлэлтийн арга 27
	1.2.6. Хөдөлгөөнт дунджийн (MA) загвар 31
	1.2.7. ARIMA 32
	1.2.8. SARIMA 34
	1.2.9. ARIMAX загвар 35
	1.2.10 State-Space-ийн загвар (Kalman Filter, DLM) 35
	1.2.11. Машин сургалтын загварууд (Random Forest Regressor) 36
	1.3. Хугацаан цувааны аргуудыг харьцуулсан дүн 37
	1.4. Хугацаан цуваан аргаар эмийн хэрэглээг таамаглахад нөлөөлөх хүчин зүйлс Нэгдүгээр бүлгийн дүгнэлт 45
	2. Урьдчилан таамаглах тооцоолол ба эмийн төлөвлөлт 46
	3. Эрүүл мэндийн байгууллагын хүүхдийн хорт хадврын эмийн хэрэгцээг урьдчилан таамаглах аргууд 47
	3.1. FORxCAST 47
	4.2. ChemoGlobe 57
	ДҮГНЭЛТ 60
	МОНГОЛ УЛСЫН ХҮҮХДИЙН ХАВДРЫН ЭМНЭЛЗҮЙН ПРАКТИКТ АШИГЛАХ БОЛОМЖИТ ЭМИЙН ХЭРЭГЦЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛУУД 60
Улаанбаатар хот 2025 он	

Энэхүү сургалтын хүрээнд хүүхдийн хорт хадврын эмийн хүртээмжийг сайжруулах, эмийн хэрэглээний урьдчилсан тооцоолол хийх арга аргачлалд суралцаж, Chemoglobe платформын тухай ойлголттой болсон. Мөн Анжали Шривастава, Мола Алессио нараас хүүхдийн хорт хадврын эмийн тооцооллын талаар холбогдох асуулт, хариулт явагдаж харилцан ярилцсан.

ДҮГНЭЛТ

ЭХЭМҮТ нь “Хүүхдийн хорт хадврын эмийн хангамжийг сайжруулах дэлхийн платформ”-ын хэрэгжих гол байгууллагын хувьд зайлшгүй шаардлагатай сургалтууд хийгдэж эмч эмнэлгийн ажилчдын мэдлэг мэдээллийг сайжруулсан. Сургалтын үр дүнд

Глобал платформын эмийн дата бүртгэл, хяналт үнэлгээ, тайлагнах үйл ажиллагаа тогтворжиж, бэхжих, хүүхдийн хорт хавдрын эмийн хадгалалт, түгээлт, хорт хавдрын эмийн хэрэглээ, гаж нөлөөг бүртгэхтэй холбоотой стандарт ажиллагааны заавар стандарт мөрдөгдөх боломж олгосон. Түүнчлэн, дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаанд ЭХЭМҮТ-ийн эмч, сувилагч, эм зүйч, эм найрлуулагч нар багаараа БНСУ-д ажлын байрны сургалтад хамрагдсан нь мэдлэгээ бататгах, гадаад сургалтаас олж авсан мэдлэгээ эргэн ирж бусаддаа дадлага сургалт хэлбэрээр түгээх ач холбогдолтой байлаа. Зөвхөн эмч, сувилагч, эм зүйч төдийгүй эмнэлгийн инженер, техникч нар хүйтэн хэлхээний удирдлага, тоног төхөөрөмжийн тохируулга сургалтад багаараа хамрагдсанаар хүүхдийн хорт хавдрын эмийг хадгалах агуулахын техникийн горим баталгаажих нөхцөл бүрдсэн.

Тайлан бичсэн:

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны дарга Б.Пүрэвцэцэг

Цусны эмгэг хавдар судлалын тасгийн их эмч Х.Сэржмядаг

Эмнэлзүйн эм зүйч М.Тэмүүлэн

Тайланг хянаж, нэгтгэсэн: ЭХЭМҮТ-ийн Эрдэм, шинжилгээ, сургалт, гадаад харилцаа хариуцсан дэд захирал Д.Энхмаа